

**УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ ОЧИРОО ОВОГТОЙ БУЛГАНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Уриа: Шинийг санаачилж, шударгаар зүтгэнэ.

1. Шударга зарчмыг баримтлан, ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлан ажиллана.
2. Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн ололтод тулгуурласан хөгжлийн бодлогыг дэмжинэ.
3. Эрүүл мэнд боловсрол, соёлын салбарын эрс шинэчлэлийг дэмжинэ.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах амьдрах, тааламжтай аюулгүй "ногоон" хот суурин газрын төлөвлөлтийг дэмжинэ.
5. Хүний эрхийг зөрчсөн, хүүхдийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгт холбогдуулах эрх зүйн хариуцлагыг чангатгах талаар хамтран ажиллана.
6. Өндөр настан болон ахмад иргэдэд зориулж тэтгэврийн дараах ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
7. Мэргэшсэн төрийн албан хаагчдыг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах замаар ажлын байрнаас хууль бусаар халдаг байдлыг таслан зогсоох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
8. Байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш хуваарилах бодлогыг дэмжинэ.
9. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар чинээлэг дундаж давхаргыг бий болгоход анхаарч ажиллана.
10. Мал аж ахуй, газар тариалангийн салбарыг шинэчлэх бодлогыг дэмжинэ.
11. Олборлох үйлдвэрлэл, бичил уурхай эрхлэгчдийн үйлдлийн улмаас хууль бусаар хөндөгдсөн газрыг нөхөн сэргээх эрх зүйн орчныг шинэчлэх санаачилга гаргана.
12. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах (тендер) үйл ажиллагааг ард иргэдийн хяналтын дор шударга нээлттэй байхад хяналт тавьж ажиллана.
13. Орон нутгаа хөгжүүлэх ард иргэдээ дэмжих зорилготой "Баялагийн сан" байгуулахыг дэмжиж ажиллана.

НЭР ДЭВШИГЧ:  О.БУЛГАН